БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/143/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Булган аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор : Д.Батцогт<br>Утас:70342716<br>Цахим хаяг: battsogtd@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Ж.Энхцоодол<br>Утас: 70342716<br>Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br>Аудитыг гүйцэтгэсэн: Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит ХХК-ийн<br>Гүйцэтгэх захирал С.Оргил<br>Утас:99197346<br>Цахим хаяг: Info@shinjlenmagadlakhui-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**......................................................................2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ............................. 4-7
**3. АУДИТЫН ТАЙЛАН**.............................................................................................7-12
**4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**..........................................................................................**13**
**4.3 Зөвлөмж**……………………………………………………………………………......….14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| МУЕА | Монгол Улсын ерөнхий аудитор |
| БЕГ | Боловсролын ерөнхий газар |
| БГ | Боловсролын газар |
| СХДАГ | Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 108

танай ________ ны № ________ т

БУЛГАН СУМЫН 1 ДҮГЭЭР
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЧАНЦАЛДУЛАМ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 1 дүгээр хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын 1 дүгээр хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Булган сумын 1 дүгээр хүүхдийн цэцэрлэг нь 2025 онд 172 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж үүнээс 172 хүүхэд үндсэн цэцэрлэгт хамрагдаж 100 хувь гүйцэтгэлээр санхүүжсэн.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудлын хэсэг

Булган сумын 1 дүгээр хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Булган аймгийн боловсролын газрын даргатай 2025 онд байгуулсан гүйцэтгэлгээний төлөвлөгөө нь 6 хөтөлбөр, 72 арга хэмжээний хүрээнд 95 хувиар үнэлэгдсэн байна.

### Санх үүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

6326050217

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **83,809,675.01** | **17,622,059.18** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 83,809,675.01 | 17,622,059.18 |
| 3121 | Төгрөг | 83,809,675.01 | 17,622,059.18 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 83,809,675.01 | 17,622,059.18 |
| **33** | **АВЛАГА** | **-** | **763,731.64** |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 763,731.64 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **85,688,832.00** | **108,901,094.00** |
| 354 | Хангамжийн материал | 85,688,832.00 | 108,901,094.00 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 2,159,420.00 | 2,312,420.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 21,809,196.00 | 20,696,848.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 1,101,000.00 | 1,441,000.00 |
| 3546 | Хүнсний материал | 9,653,990.00 | 7,297,720.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 50,965,226.00 | 77,153,106.00 |
| **I** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **169,498,507.01** | **126,523,153.18** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **991,281,250.42** | **941,907,739.43** |
| 392 | Биет хөрөнгө | 954,292,917.06 | 904,961,072.71 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 957,730,775.43 | 957,730,775.43 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (129,439,786.76) | (154,956,759.80) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 76,361,496.00 | 78,764,196.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (12,884,291.49) | (30,234,834.48) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,178,647.00 | 50,323,647.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18,040,928.28) | (25,803,848.88) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 35,011,555.18 | 35,011,555.18 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (857,500.02) | (6,206,107.74) |
| 39217 | Ном | 232,950.00 | 332,450.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 36,988,333.36 | 36,946,666.72 |
| 39301 | Програм хангамж | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,391,666.64) | (1,433,333.28) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 36,780,000.00 | 36,780,000.00 |
| **II** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **991,281,250.42** | **941,907,739.43** |
| **III** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,160,779,757.43** | **1,068,430,892.61** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 35,823.57 | - |
| 413 | Өглөг | 35,823.57 | - |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | 35,823.57 | - |
| **IV** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **35,823.57** | **-** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,160,743,933.86** | **1,068,430,892.61** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 256,052,711.85 | 256,052,711.85 |
| 51101 | Өмч: - төрийн | 256,052,711.85 | 256,052,711.85 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 447,528,180.35 | 355,215,139.10 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 447,528,180.35 | 447,528,180.35 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | - | (92,313,041.25) |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 457,163,041.66 | 457,163,041.66 |
| **V** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,160,743,933.86** | **1,068,430,892.61** |
| **VI** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,160,779,757.43** | **1,068,430,892.61** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **929,339,600.00** | **988,281,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **822,910,600.00** | **819,943,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 822,910,600.00 | 819,943,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **106,429,000.00** | **168,337,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 106,429,000.00 | 168,337,400.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 112,063,302.18 | 36,203,900.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 112,063,302.18 | 36,203,900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,000,000.00 | 20,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,000,000.00 | 20,000,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 82,049,302.18 | 3,022,900.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 20,014,000.00 | 13,181,000.00 |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,041,402,902.18** | **1,024,484,900.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 940,255,588.97 | 1,116,797,941.25 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **936,834,734.14** | **1,116,338,501.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **607,605,407.57** | **707,828,953.36** |
| 210101 | Үндсэн цалин | 415,499,795.57 | 439,959,051.87 |
| 210102 | Нэмэгдэл | 172,030,112.00 | 192,044,867.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 21,383,750.00 |
| 210104 | Урамшуулал | 20,075,500.00 | 54,441,283.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **74,489,251.78** | **85,858,338.90** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,702,929.78 | 59,667,469.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,137,700.00 | 7,066,699.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,068,900.00 | 3,533,347.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,068,900.00 | 3,118,166.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,510,822.00 | 12,472,656.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **101,515,425.17** | **160,877,959.81** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,063,579.09 | 8,457,581.81 |
| 210302 | Түлш, халаалт | 83,828,976.00 | 139,337,352.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,622,870.08 | 13,083,026.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **477,875.00** | **1,418,968.00** |
| 210408 | Бараа материал акталсаны зардал | 477,875.00 | 1,418,968.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **67,975,496.00** | **68,106,570.00** |
| 210502 | Хоол, хүнс | 67,975,496.00 | 68,106,570.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,126,720.00** | **6,994,900.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,126,720.00 | 6,994,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,675,705.00** | **3,565,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,675,705.00 | 3,565,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 81,968,853.62 | 81,687,610.99 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **31,599,660.00** | **14,889,950.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,022,600.00 | 10,776,950.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 45,346,593.62 | 56,020,710.99 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 3,420,854.83 | 459,440.19 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,675,705.00 | 3,565,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,420,854.83 | 459,440.19 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,420,854.83 | 459,440.19 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **940,255,588.97** | **1,116,797,941.25** |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 101,147,313.21 | (92,313,041.25) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 408,083.50 | - |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **408,083.50** | **-** |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **100,739,229.71** | **(92,313,041.25)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* / төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **939,339,600.00** | **1,008,281,000.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 10,000,000.00 | 20,000,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 10,000,000.00 | 20,000,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,000,000.00 | 20,000,000.00 |
| 1200042 | Тусах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,000,000.00 | 20,000,000.00 |
| 120009 | Бусад орлого | 2,736,600.00 | 250,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 929,339,600.00 | 988,281,000.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **822,910,600.00** | **819,943,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 822,910,600.00 | 819,943,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **106,429,000.00** | **168,337,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 106,429,000.00 | 168,337,400.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **888,423,240.78** | **1,070,844,315.83** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 888,423,240.78 | 1,070,844,315.83 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 885,002,385.95 | 1,070,384,875.64 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **607,569,584.00** | **705,477,715.83** |
| 210101 | Үндсэн цалин | 415,463,972.00 | 437,607,814.34 |
| 210102 | Нэмэгдэл | 172,030,112.00 | 192,044,867.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 21,383,750.00 |
| 210104 | Урамшуулал | 20,075,500.00 | 54,441,283.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **74,489,251.78** | **88,245,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,702,929.78 | 59,867,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,137,700.00 | 7,094,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,068,900.00 | 3,547,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,068,900.00 | 3,547,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,510,822.00 | 14,188,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **101,515,425.17** | **160,877,959.81** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,063,579.09 | 8,457,581.81 |
| 210302 | Түлш, халаалт | 83,828,976.00 | 139,337,352.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,622,870.08 | 13,083,026.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **70,470,700.00** | **65,750,300.00** |
| 210502 | Хоол, хүнс | 70,470,700.00 | 65,750,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,492,720.00** | **7,000,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 1,492,720.00 | 7,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,336,705.00** | **3,675,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,336,705.00 | 3,675,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 27,128,000.00 | 39,358,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **19,957,900.00** | **32,617,700.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,170,100.00 | 6,740,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,420,854.83 | 459,440.19 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,336,705.00 | 3,675,200.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,420,854.83 | 459,440.19 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,420,854.83 | 459,440.19 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **50,916,359.22** | **(62,563,315.83)** |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 14,609,400.00 | 3,624,300.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 14,609,400.00 | 3,624,300.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 3,558,900.00 | 1,359,800.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 11,050,500.00 | 2,264,500.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (14,609,400.00) | (3,624,300.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 36,306,959.22 | (66,187,615.83) |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **83,809,675.01** | **83,809,675.01** |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **17,622,059.18** | **17,622,059.18** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Хуримтлагдсан үр дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **256,052,711.85** | **457,163,041.66** | **346,788,950.64** | **1,060,004,704.15** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | **-** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 100,739,229.71 | 100,739,229.71 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **256,052,711.85** | **457,163,041.66** | **447,528,180.35** | **1,160,743,933.86** |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **256,052,711.85** | **457,163,041.66** | **447,528,180.35** | **1,160,743,933.86** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (92,313,041.25) | (92,313,041.25) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **256,052,711.85** | **457,163,041.66** | **355,215,139.10** | **1,068,430,892.61** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Эдийн засгийн ангилал | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО** | **988,281,000.00** | **988,281,000.00** | **-** | **100.00** |
| **131** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **819,943,600.00** | **819,943,600.00** | **-** | **100.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 819,943,600.00 | 819,943,600.00 | - | 100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | - | #DIV/0! |
| **132** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **168,337,400.00** | **168,337,400.00** | **-** | **100.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 168,337,400.00 | 168,337,400.00 | - | 100.00 |
| 133 | ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС | | | - | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 20,000,000.00 | 20,000,000.00 | - | 100.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,000,000.00 | 20,000,000.00 | - | 100.00 |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | - | #DIV/0! |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,008,281,000.00** | **1,008,281,000.00** | **-** | **100.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,084,007,600.00 | 1,070,844,315.83 | (13,163,284.17) | 98.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,084,007,600.00 | 1,070,384,875.64 | (13,622,724.36) | 98.74 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **709,446,700.00** | **705,477,715.83** | **(3,968,984.17)** | **99.44** |
| 210101 | Үндсэн цалин | 463,594,400.00 | 437,607,814.34 | (25,986,585.66) | 94.39 |
| 210102 | Нэмэгдэл | 211,266,400.00 | 192,044,867.66 | (19,221,532.34) | 90.90 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 21,383,750.00 | 21,383,750.00 | |
| 210104 | Урамшуулал | 34,585,900.00 | 54,441,283.83 | 19,855,383.83 | 157.41 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **88,245,400.00** | **88,245,400.00** | **-** | **100.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,867,600.00 | 59,867,600.00 | - | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,094,500.00 | 7,094,500.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,547,200.00 | 3,547,200.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,547,200.00 | 3,547,200.00 | - | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,188,900.00 | 14,188,900.00 | - | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **161,337,400.00** | **160,877,959.81** | **(459,440.19)** | **99.72** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,550,000.00 | 8,457,581.81 | (1,092,418.19) | 88.56 |
| 210302 | Түлш, халаалт | 139,054,200.00 | 139,337,352.00 | 283,152.00 | 100.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,733,200.00 | 13,083,026.00 | 349,826.00 | 102.75 |
| **2105** | **Нормативт зардал** | **71,179,200.00** | **65,750,300.00** | **(5,428,900.00)** | **92.37** |
| 210502 | Хоол, хүнс | 71,179,200.00 | 65,750,300.00 | (5,428,900.00) | 92.37 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,000,000.00** | **7,000,000.00** | **-** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 7,000,000.00 | 7,000,000.00 | - | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,675,200.00** | **3,675,200.00** | **-** | **100.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,675,200.00 | 3,675,200.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **43,123,700.00** | **39,358,300.00** | **(3,765,400.00)** | **91.27** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,333,600.00 | 32,617,700.00 | (3,715,900.00) | 89.77 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,790,100.00 | 6,740,600.00 | (49,500.00) | 99.27 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 459,440.19 | 459,440.19 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох | - | 459,440.19 | 459,440.19 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 459,440.19 | 459,440.19 | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 3,624,300.00 | 3,624,300.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | - | 3,624,300.00 | 3,624,300.00 | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 1,359,800.00 | 1,359,800.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 2,264,500.00 | 2,264,500.00 | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **1,084,007,600.00** | **1,074,468,615.83** | **(9,538,984.17)** | **99.12** |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **83,809,675.01** | **83,809,675.01** | **-** | **100.00** |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **17,622,059.18** | **17,622,059.18** | **-** | **100.00** |

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Булган аймгийн Булган сумын 3-р сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Шинжлэн Магадлахуй ЭЗШ аудит ХХК" ХХК-ий аудитор С.Дарьсүрэн, Б.Хоролбат, Л.Магсаржалам нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал С.Оргил анхан шатны чанарын хяналтыг, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Булган аймгийн Булган сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны

батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардал 903,032.64 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,545.49 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 10,159.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Тус байгууллага нь цалин, шимтгэлийн зардал болон бусад зардлуудаас нийт 17,622.1 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож төрийн сангийн харилцах дансанд үлдээсэн байна. Орон нутгийн санхүүжилтээс 459.4 мянган төгрөгийг хэмнэн буцаан төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

### 3.4 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 3.4.1 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймгийн Булган сумын 1 дүгээр цэцэрлэг нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 171 мэдээллийг зохих хугацаанд байршуулсан байна.

#### 3.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ.

***Албан шаардлага***

*Илрүүлэлт:* Тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, тендер зарлаагүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Албан шаардлага/

*Шийдвэрлэсэн нь*: Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөн баталж, дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээх, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг цахим системд мэдээлж байх.

### 3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 3.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан болон төлөвлөх шатны ажлыг Фас системээр хийж гүйцэтгэсэн.

#### 3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах, таслан зогсоох 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулан fas системээр үнэлсэн байна. Үүнд:

- Тайлант жилд 102,063.3 мянган төгрөгийн тушаал шийдвэрүүдийг шилэн дансанд дутуу байршуулсан зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсэн.
  *Албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн.*
- Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоолны нормыг энгийн хүүхдийн нормоор 45.0 мянган төгрөгөөр дутуу тооцсон зөвлөмж хүргүүлсэн байна.
  *Зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн.*
- Тайлант онд хүүхдийн аюулгүй байдлыг хангас үүднээс гараас гарт зарчмыг баримтлаагүй бүртгэл хангалтгүй учир зөвлөмж хүргүүлсэн байна.
  *Зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн.*

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 102,063.3 | 1 | 102,063.3 | 100.0 |
| Зөвлөмж | 2 | 45.0 | 2 | 45.0 | 100.0 |
| Нийт дүн | 3 | 102,108.3 | 3 | 102,108.3 | 100.0 |

Өмнөх аудитаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийг Булган сумын 1 дүгээр цэцэрлэг нь шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлж ажилласан байна.

### 3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулалт
2. Хоол хүнсний материалын худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэлд анхаарах нь зүйтэй.

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар нийт 2 зөрчил[2] илэрснээс 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн асуудлаар зөрчил нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өгсөн болно.

### 5.1 Зөвлөмж

**5.1.1 Илрүүлэлт:** Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй байгаа, Бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн долоо хоногт нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 -т 'тасралтгүй байх' гэсэн зарчим, 13.1' Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно' гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Цаг тухай бүрд нь орлого, зарлагын гүйлгээг программд оруулан шивж байх, санхүүгийн программыг бүрэн эзэмшиж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн программыг өдөр | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй байгаа, Бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн долоо хоногт нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **0** | | | **0** | **0** | **1** | **0** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, тендер зарлаагүй | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Нийт дүн | 2 | 0 | | | 1 | 0 | 1 | 0 |